

СҮХБААТАР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2024.10.02

Баруун-Урт сум

1. Удирдлага зохион байгуулалтын талаар

Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл, 7.1.6, 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйл, Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 303 дугаар тогтоол, 2020 оны А/173, А/133 дугаар тушаал болон холбогдох дүрэм журам, Гамшгаас хамгаалах төрөөс баримтлах бодлого хөтөлбөр, Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр, Онцгой байдлын ерөнхий газрын зорилт, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Онцгой байдлын газрын зорилтыг удирдлага болгон ажиллаж байна.

2. Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшиг, аюулт үзэгдлийг анхааруулах сэрэмжлүүлэх мэдээ мэдээллийг ард иргэдэд шуурхай хүргэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газар, Ус цаг уур орчны шинжилгээний албанаас ирүүлсэн цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг 12 удаа хүлээн авч орон нутгийн “BBS” телевиз болон SMS SENDER IRS программ ашиглан Аймгийн онцгой комиссын гишүүд болон, сумдын тамгын газрын дарга нар, хөдөөгийн багуудын малчин өрхүүдэд багц мессежийн үйлчилгээг ашиглан 5 удаа 13 сумын давхардсан тоогоор 17000 хүнд хүргэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, мөн Онцгой байдлын газрын “Сүхбаатар Онцгой байдлын газар” facebook, пэйж хуудсаар иргэдэд цаг агаарын мэдээллийг хүргэн ажилласан.

“Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”, “Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааны нийтлэг заавар”-ыг хэрэгжүүлэх ажил, Монгол Улсын шадар сайдын баталсан удирдамжийн хүрээнд аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газартай хамтран үер, усны ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан батлуулсан. “Үер ус ослоос урьдчилан сэргийлье” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Онцгой байдлын газраас 20 алба хаагч Баруун-Урт сумын Баруун гол, Эрдэнэцагаан сумын Чоно-гол, Түмэнцогт сумын Хэрлэн голын эрэг дагуу Гал түймэр унтраах, аврах 15, 47 дугаар анги, Эрэн хайх аврах салбарын алба хаагчид үер усны аюулаас урьдчилан сэргийлэх эргүүл хяналт хийж гол, нуурын эрэг дагуу нутаглаж байгаа 36 айл, өрх, аялаж, зугаалж байгаа 460 гаруй иргэнд үер усны ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмж өгч нийт 500 ширхэг санамж, гарын авлага тарааж ажилласан. Ард иргэд, айл өрхүүдэд ахуйн гал түймэр болон үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх, ухуулга сурталчилгааг хүн ам олноор цугладаг Зүүн бүс худалдааны төв, Номин супер маркет, Жавхлант худалдааны төв, Дээж худалдааны төв, Сүхбаатарын талбай, Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, Сүхбаатар худалдааны төв, Баруун-Урт сумын ус түгээх 18 цэг болон гэр хорооллын айл өрхүүдэд сэрэмжлүүлэг хүргэн нийт 500 ширхэг санамж материал тараан урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсан.

Үер усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Түмэнцогт, Эрдэнэцагаан сумдад үер усны ослоос урьдчилан сэргийлэх 15 самбарын мэдээллийг шинэчилэн Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт байрлах Баруун голын эрэг дагуу эрсдэл өндөр 5 цэгт усны ослоос урьдчилан сэргийлэх, анхааруулах самбаруудыг шинээр байрлуулсан.

Баруун-Урт сумын төвөөр дамжин өнгөрч буй 2,5 км урттай үерийн далан, шуудуу, авто замуудын ус зайлуулах хоолойн хог, лаг шавар, хуримтлагдсан хайрга, шороог Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-газар хариуцан цэвэрлэж ус урсан гарахад саадгүй болгосон.

Цаг агаарын сэрэмжлүүлэх мэдээ, Үер, усны ослоос урьдчилан сэргийлье, Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх постерийн эх бэлтгэж Онцгой байдлын газрын “Сүхбаатар онцгой байдлын газар” facebook, пэйж болон бусад сумдын цахим хуудас, мэдээллийн сайтуудаар дамжуулан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, шторкуудыг цахим орчинд нийтэлж 24,253 иргэний хандалтыг авсан.

Зохион байгуулсан сургалтын талаар

Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу ангиллын сургалтыг 71 аж ахуйн нэгжид, байгууллагад нийт 111 цагийн сургалтаар “Гамшгаас хамгаалах тухай” хууль, “Галын аюулгүй байдлын тухай” хууль, холбогдох дүрэм, журам, “Гамшгаас хамгаалах Бэлэн бай” багц “What3words” хичээлүүдээр танхимын сургалт, гал унтраах дадлагыг Гал түймэр унтраах, аврах 15, 47 дугаар ангийн салааны захирагч, Урьдчилан сэргийлэх тасаг хамтран нийт 1019 ажилтан, албан хаагчдыг хамруулан зохион байгуулан ажилласан.

Гамшгаас хамгаалах ангиллын сургалт:

Төрийн болон нутгийн захиргааны байгууллага хуулийн этгээд-41удаа 82 цаг 249 хүн
Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги сургалт-6 удаа 12 цаг, 59 хүн
Иргэний сургалт-3 удаа 3 цаг, 64 хүн
Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сургалт-11 удаа 7 цаг 364 хүн
Сургуульд элсэхээс өмнөх насны сургалт- 10 удаа 5 цаг 283 хүн
Ангиллын сургалтад нийт:71 удаа, 109 цаг, 1019 хүн хамрагдсан байна.

3. Хяналт шалгалтын талаар

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, Шатахуун түгээх станц, АХЦС, Уул уурхайн баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж, Боловсролын байгууллагын барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад М.Дамба, ахлах дэслэгч А.Галсандорж, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч ахлах дэслэгч С.Батхуяг нар Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж буй Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, Шатахуун түгээх станц, АХЦС, Уул уурхайн баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж, Боловсролын байгууллагын барилга байгууламжид төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс 08 дугаар сарын 31-ны өдрийн хооронд зохион явуулж ажиллалаа. Төлөвлөгөөт хяналт шалгалтаар 37 барилга байгууламжийг хамруулан нийт 247 зөрчил дутагдлыг илрүүлж, газар дээр нь 58 зөрчлийг арилгуулж, бусад зөрчлийг арилгуулахаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 28 мэдэгдэл 9 тус тус бичиж эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж хэрэгжилтийг хангуулахаар ажиллалаа. Галын аюулгүй байдлын шаардлага хангаж хүсэлт гаргасан 18 аж ахуйн нэгж байгууллагад галын аюулгүй байдлын дүгнэлт олгон 450.000 төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, бусад аж ахуйн нэгж, байгууллагад хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллаж байна.

4. Холбоо зарлан мэдээллийн талаар

Холбоо Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 178, 179 дүгээр тушаал, 2011 оны Засгийн газрын 339, 340-р тогтоол, 2013 оны 11-р сарын 25-ны А/861, 2015 оны 06-р сарын 12-ны А/182, 2017 оны Засгийн газрын 67-р тогтоол бусад холбогдох дүрэм журмуудыг үндэслэн Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын холбоо, зарлан мэдээллийн бэлтгэл бэлэн байдал, мэдээллийн аюулгүй байдлыг ханг

Гамшгийн шуурхай удирдлагын даргын 2021 оны 11 сарын 1-ний 6/2216 тоот үүргийн дагуу мэдээллийн аюулгүй байдал алдагдах эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ОБЕГ-ын даргын 2020.10.26-ны №А/233 тушаалын “Онцгой байдлын байгууллагын цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ын 2.1.4, 2.2.1, 3.3.6, 4.4.1 дэх заалтуудын дагуу компьютер, принтер, гадаад болон дотоод сүлжээний нэгдсэн топологи зураглал, “Онцгой байдлын байгууллагын цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-д заасан хавсралтын 1-4 дүгээр загварын дагуу техник ашиглалтын паспортыг тус тус боловсруулж, хэрэглэгч тус бүрт хуваарийн дагуу засвар үйлчилгээ хийх болгонд хөтөлж, алба хаагчдын компьютерын гадаад болон дотоод сүлжээнд сар бүр хяналт, засвар үйлчилгээ хийж ажилласан.

5. Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээний чиглэлээр

Аймгийн Засаг даргын 2024 оны А/108 дугаар захирамжаар байгуулсан гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгээр үерийн эрсдэлийн үнэлгээ-1, гангийн эрсдэлийн үнэлгээг 1 удаа нийт 2 удаагийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж зөвлөмж боловсруулж,

Улсын Онцгой Комиссын Шуурхай штаб, ОБЕГ-т хүргүүлж ажилласан. Эрсдэлийн үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийг аймгийн Онцгой Комисс, Шуурхай штабт танилцуулж, авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг төлөвлөх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэхэд дэмжлэг үзүүлж ажилласан.

Аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг хамруулсан ангиллын сургалтаар гамшгийн эрсдэлийн тухай ойлголт, эрсдэлийн үнэлгээ хийх заавар, дүрэм, журмын талаар 16 аж ахуйн нэгж байгууллагын 630 ажилтан, албан хаагч, сурагчдад сургалт зохион байгуулсан.

6. Эрүүл мэндийн талаар

Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 15 дугаар анги, эрэн хайх, аврах салбарын харуул ээлж болон эрүүл мэндийн тусламж шаардлагатай 74 алба хаагч, тамирчид болон өдрийн 18 алба хаагч эрүүл мэндийн анхан шатны үзлэг хийж, 8 алба хаагчид эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлснээс 2 алба хаагч орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан. Онцгой Жаргалант сувилалд 12 алба хаагч, 4 ар гэрийн гишүүдийг нөхөн сэргээх, сэргээн засах эмчилгээнд хамруулаад байна.

Зоонозын Өвчин Судлалын Үндэсний төвөөс товллын дагуу хийгддэг байгалийн голомтот хурц халдварт “Тарваган тахал”-ын вакцинжуулалтад 61 алба хаагчийг хамруулж, мэдээ, тайланг ЭМГ, ОБЕГ-т хүргүүлсэн.

Байгууллагын цэвэрлэгээ, үйлчилгээнд хяналт тавьж өрөө тасалгааны цэвэрлэгээг өдөр бүр батлагдсан хуваарийн дагуу, их цэвэрлэгээг 7 хоног бүрийн баасан гарагт газрын хэмжээнд бүх алба хаагчид хамруулан хийлгэж байна. Томилгоот ээлжийн алба хаагчдын хоолыг батлагдсан хоолны цэсний дагуу олгодог ба өдөр тутамдаа амт чанар, боловсруулалт, орц нормыг эмч-сэтгэл зүйч, ёс журам сахиулах эргүүлүүд хяналт тавьж ажилладаг.

Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын хүрээнд 2 аж ахуйн нэгж, байгууллагын 14 ажилтан, алба хаагчид эмнэлгийн анхан шатны тусламжийн сургалт, дадлага орж болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг авран хамгаалах чадавхийг дээшлүүлсэн.

7. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлын талаар

Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын даргын 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн албан бичгийн дагуу Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах үндсэн болон тусгай зориулалтын автомашины жолооч бүрэлдэхүүний 03 дугаар улирлын сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 26, 27-ны өдөр зохион байгуулж тайланг, gttg.guh@gmail.com цахим хаягаар, хүргүүлсэн. Мөн газрын даргын тушаалаар ГТУА 15-дугаар ангийн 2 жолоочийг Маз шатны автомашин дээр дадлагажуулж байна.

Гал түймэр унтраах аврах 15-47 дугаар ангиас шаардлагатай сэлбэгийн судалгааг улирал бүр гаргуулж шийдвэрлэж байна. Франц улсад үйлдвэрлэгдсэн РЕНО автомашины үүрэг гүйцэтгэлтийн талаарх судалгааг e.dashnyam@nema.gov.mn хаягт хүргүүлсэн.

Өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг хангахад шаардагдах материал сэлбэгийн тооцоог гаргаж ОБЕГ-т хүргүүлж, өвлийн улирлын үйлчилгээ хийхэд 3,200,000 төгрөг шийдвэрлэсэн.

Улбар шар кодтой түргэн цугларалтад хамрагдаж аранзны болон автомашин техник, багаж зэвсэглэмжийн бэлэн байдал шалгуулсан. Зил-131 автомашины моторыг боож бэлэн байдал хангасан. Тэргүүн дэд даргын үүргийн хүрээнд 115 дугаар ангиас хуваарилсан БМП-1 загварын машинийг 2024 оны 09 сарын 19-ны өдөр асааж бэлэн байдал хангасан. Ковш дугуйт ачигчийн шаардлагатай сэлбэгийг нийлүүлсэн компаниар дамжуул захиалсан. Гал түймэр унтраах аврах 115 дугаар ангиас нийлүүлсэн 38ш дугуйг хүлээж авсан.

Тус газрын алба хаагчдад АБДТ-ийн багны засварчинаар “Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм”, Замын цагдаагийн зохицуулагчаар “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм”, “Гал түймэр унтраах автомашины жолоодлогын дадлага сургалт”-ыг зохион байгуулсан. Мөн спортын тэмцээн болон сургалтаар, чөлөөгөөр явсан алба хаагчдаас ХАБЭА зааварчилгаа авсан.

ГТУА 15, 47 дугаар анги Эрэн хайх,аврах салбарын алба хаагчдад ОББ-ын ХАБЭА дүрмийн хичээл сургалтыг өдөр тутмын хичээлийн хуваарьт оруулж зохион байгуулж байна.

Өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг хангах, техник тоног төхөөрөмжийг урсгал засвар үйлчилгээнд шаардагдах зардлыг ОБЕГ-т хүргүүлж 3,200,000 төгрөг шийдвэрлүүлж улирлын үйлчилгээ хийхээр бэлдээд байна.

“ОББ-ын тусгай зориулалтын болон шуурхай албаны автомашины ашиглалтад анхаарах зарим асуудал, засвар үйлчилгээ хийх үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа”, сэдвүүдээр сургалт зохион байгуулж, Замын цагдаагийн байцаагчаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль, дүрмээр хичээл орсон.

ГТУА 15 дугаар ангийн шатны автомашины хөлны мэдрэгч сольсон мөн Хово автомашины багжны тагнууд, ТСВ-8 автомашины ган, перда диск зэргийг шинээр сольж тавьсан, Dongfeng автомашины консны аппаратны саалник, ЭХАС-ын 03-15сүэ автомашинд чагтан гол, нумны втулк, консны аппарат, ган, перда диск, шинээр сольж раммны бэхэлгээ хийсэн. Мөн шуурхай албаны 02-02СҮЭ автомашинд 4ш амардизатор 1,000,000 төгрөгөөр захиалсан. ГТУА 47 дугаар ангийн шуурхай албаны 00-07сүа автомашины хойт мост шийдвэрлэж бэлэн байдал хангасан.

Хүйтний улирал эхэлж байгаатай холбогдуулж тээврийн хэрэгсэл, багаж зэвсэглэмжинд үзлэг шалгалт хийж, шаардлагатай засвар үйлчилгээг хариуцсан жолооч нараар хийлгэж байна.

8. Гал түймэр, гамшиг осолтой тэмцэх талаар.

Гал түймэр унтраах, аврах 15 дугаар анги нь томилгоот харуул ээлжинд 91-н удаагийн 2184 цагийн үүрэг гүйцэтгэлээ. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэмжээнд 2024 оны 3 дугаар улиралд Объектын гал түймрийн зөрчлийн дуудлага 3, Объектын гал түймрийн дуудлага 3 удаа гарч ард иргэдийн 25,3 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан.

Д\Д	Дуудлагын дугаар	Салааны дугаар	Гал гарсан газрын хаяг	Он сар өдөр	Зарцуулсан			Хүч		Хугацаа			Аварсан			Аварсан хөрөнгө	хохирол
					Ус	Хөөс	Шатахуун	1 тасаг	2 тасаг	30 минут	30-60 минут	60-аас дээш	Хөрөнгө	Байшин гэр	Хүн		
1	4	2 дугаар салаа	. Баруун-Урт сумын 3 дугаар баг Чулуутийн 701 тоотод Амбаар шатаж байна	2024 он 08-р сарын 26–ны өдөр	1 тн	-	7.6л	1	-		13минут	-	-	3*2 харьцаатай амбаар		8 сая	500мянга
2	5	1 дүгээр салаа	Баруун-Урт сумын 9 дүгээр баг “Хайлааст”-ын 2909 тоотод амбаар шатаж байна.	2024.09 07-ны өдөр	1 тн	-	7,6 л	1	-		8 минут	-	-	2*3 хэмжээтэй амбаар		17сая	1 сая

3	6	2 дугаар салаа	Баруун-Урт сумын 2 дугаар баг "Уртын"-ын 2 тоотод амбаар шатаж байна	2024.09.11-ний өдөр	1,8 тн	-	6 л	1			13 минут	-	-	3*4 хэмжээтэй амбаар	250 мянга	1,5 сая
---	---	----------------	--	---------------------	--------	---	-----	---	--	--	----------	---	---	----------------------	-----------	---------

Гал түймэр унтраах, аврах 47 дугаар анги нь томилгоот ээлжид 92-н удаа 2208 цагийн үүрэг гүйцэтгэхдээ объектын гал түймрийн дуудлага-1, хээрийн түймрийн дуудлага-3 удаа тус тус үүрэг гүйцэтгэж ард иргэдийн 10 сая төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалсан байна.

д/д	Огноо /Цаг минут/	Гал гарсан газар /хаяг, овог нэр, юу шатсан/	Ус	Хөөс	Шатахуун	Аварсан Хөрөнгө /төгрөгөөр/	Урьдчилсан байдлаар Хохирол /төгрөгөөр/
1	2024 он 07-р сарын 07-ны өдөр	Эрдэнэцагаан сум Алтан овоо 8-р баг Баясгалантын 1-3 тоот иргэн Д.Үүрийнтуяагийн эзэмшлийн 4*6 харицаатай пин.	1 тн	-	6,8 л	10,000,000	2,000,000₮
Нийт			1тн	-	6,8 л	10,000,000	2,000,000₮

Нийт Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 15, 47 дугаар анги нь объектын гал түймрийн дуудлага-4, хээрийн түймрийн дуудлага-3 тус тус ажиллаж ард иргэдийн 35,3 сая төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалсан байна.

Гурван шатны сургалт. ГТУА 15-р анги

Гал түймэр унтраах тархалтын дадлага, сургалтыг урьдчилан сэргийлэх тасагтай хамтран хичээл сургалтыг сургалтыг "1-р цэцэрлэг" "Дашваанжил" газан колонк, "9-р цэцэрлэг", "Өөдлөх дөл" газан колонк, "Нутаг шим" ус цэвэршүүлэх үйлдвэр зэрэг газруудад дадлага болон танхимаар зохион байгуулж ажилласан. Сургалтанд аж ахуйн нэгж, байгууллагаас 154 хүн хамрагдсан. Онцгой байдлын албанаас 44 алба хаагч оролцсон.

Тактикийн дадлага сургалтын "Дарьганга" зочид буудал зохион байгуулагдаж, мэргэжлийн анги байгууллагын 34 ажилтан алба хаагч, 5 техниктэйгээр оролцлоо.

Алба хаагчдын гал унтраах ур чадвар, сэтгэл зүй, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор өдөр тутмын дасгал сургуулийг 91 удаа 136.5 цаг давхардсан тоогоор 493 алба хаагчийг хамруулан амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах, аврах олс, байлдааны тархалт, байлдааны хувцас өмсөл зэргээр хийж ОБЕГ даргын 2022 оны А/300 тоот тушаалын хэрэгжилтийн ханган ажилласан.

ГТУА 47-р анги

Онцгой байдлын ерөнхий газраас 2021 оны 06 сарын 22-ны өдрийн А/135 тоот тушаалаар батлагдсан гал түймэр унтраах, тархалтын дадлага сургалт, шуурхай төлөвлөгөө, карт боловсруулах аргачлалын дагуу 07-р сард Тархалтын дадлага сургалтыг "Нутгийн удирдлагын ордон", "Далай булаг хүнсний дэлгүүр", "Элбэг хүнсний дэлгүүр", 08-р сард Тархалтын дадлага сургалтыг "Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр", "Молор-Эрдэнэ хүнсний дэлгүүр", "Баянбулаг-2 хүнсний дэлгүүр", 09-р сард Тархалтын дадлага сургалтыг "Дэлгэрэх хүнсний дэлгүүр", "Билгүүн хүнсний дэлгүүр" зэрэг байгууллагуудад шуурхай төлөвлөгөө болон тархалтын дадлага сургалтыг танхимаар зохион байгуулж, байгууллагын алба хаагчдад гал унтраагуур анхан шатны багаж зэвсэглэмжийг хэрхэн зөв ажиллуулах талаар сургалт зохион байгууллаа. Сургалтад аж ахуй нэгж байгууллагаас 76 иргэн хамрагдсан. Гал түймэр унтраах, аврах ангиас давхардсан тоогоор 66 алба хаагч оролцсон.

Алба хаагчдын гал унтраах ур чадвар, сэтгэл зүй, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор өдөр тутмын дадлага сургалтыг 92 удаа 184 цаг давхардсан тоогоор 552 алба хаагчийг хамруулан гал унтраах тархалт, автоцистернийг усан дээр байрлуулах, хүн нэг бүрийн хөдөлмөр хамгааллын хувцас зэвсэглэмжийг өмсөх зэрэг нормативаар сургалтыг ангийн цагийн хуваарийн дагуу зохион байгуулсан.

Нийт Тархалтын дадлага сургалтыг 13 удаа, Тактикийн дадлага сургалтыг 1 удаа зохион байгуулж ААНБ-н 230 алба хаагчид гал түймэр унтраах анхан шатны мэдлэг олгож ажилласан. Гал түймэр унтраах, аврах 15, 47 дугаар ангиас давхардсан тоогоор 110 алба хаагч хамрагдсан байна.

Өдөр тутмын дадлага сургалтад давхардсан тоогоор 1045 алба хаагч 2024 оны 3 дугаар улиралд хамрагдсан тоон үзүүлэлттэй байна.

9. Эрэн хайх, аврах ажиллагааны чиглэлээр

Бэлтгэл бэлэн байдал

Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаал болон Онцгой байдлын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/99 дугаар тушаалын бие бүрэлдэхүүнд танилцуулж баяр амралтын өдөр үүрэг гүйцэтгэх бүлгийн бүрэлдэхүүний томилгоог танилцуулж үүрэг чиглэл өгч ажилласан.

Энэ сард Эрэн хайх, Аврах салбарын 16-н алба хаагч өдрийн 08-н цагаар харуул ээлжид үүрэг гүйцэтгэж ажилласан.

Эрэн хайх, аврах салбарын алба хаагчдын бэлтгэл бэлэн байдлыг хангах удирдамж гаргаж Онцгой байдлын газрын даргаар батлуулсан.

Онцгой байдлын газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 05 –ний өдрийн А/51 тушаалаар баталсан Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журмын /хавсралт-г/ Эрэн хайх, аврах салбарын алба хаагчдын “зарлан мэдээллийн” дохио дамжуулах бүдүүвч схем, гэрийн хаяг, шаардлагатай үед холбоо барих утасны дугааруудад 1 удаа, алба хаагчдын утсанд 4 удаа тодотгол хийсэн.

Гамшиг, осолд ажилласан талаар

Сүхбаатар аймаг Баруун-Урт сум 2-р баг "Баруун-Уртын гол" гэдэг газар /аймгийн төвөөс баруун зүгт 2 км, сумын төвөөс баруун зүгт 2 км/-т Баруун-Урт сумын харъяат иргэн М /12 настай, эмэгтэй/ нь 2024.07.08-ны өдрийн 14:44 цагт нуурын усанд осолдсон тухай дуудлагыг 2024.07.08-ны өдрийн 14:44 цагт хүлээн авсан. Тус аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх аврах салбарын 4 алба хаагч, 1 автомшинтай ангийн байрлалаас гарч 14:55 цагт очиход, Иргэн М /12 настай, эмэгтэй/ Баруун-Уртын голын тогтоол усанд живсэн байсныг 1.7 метрын гүнд шумбалт хийж 7 минут ажиллаж, 15:02 цагт буцалтгүй нэрвэгдэгч болсон байсныг уснаас гарган Цагдаагийн газрын мөрдөн байцаагч, ахлах дэслэгч М.Азбаярт шилжүүлж өгсөн.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын "Далан түрүү" гэдэг газар аймгийн төвөөс 170км сумын төвөөс 30км. Улаанбаатараас Уулбаян сумын чиглэлд явж байсан иргэн Б.Амартүвшин аялалын 460 автомашин шаварт суусан дуудлагыг 22:30 цагт хүлээн авсан. Дуудлагын дагуу ЭХАС-с коуш автомашинтай 2 алба хаагч 22:55 цагт ангийн байрлалаас хөдөлж, 23:15 цагт татан гаргасан.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын нутгаар 2024 оны 8-р сарын 02-ны өдрийн 17:17 цагаас 18:45 цагийн хооронд орсон аадар борооны улмаас гэр, байшин, орон сууцны зоорийн давхар усанд автсан тухай нийт 22 дуудлага мэдээллийн хүлээн авч ажиллалаа. Дуудлага мэдээллээр Онцгой байдлын газраас 26 алба хаагч, 5 техник хэрэгсэл, мэргэжлийн ангиас 6 албан хаагч, 2 техник хэрэгсэлтэйгээр ажиллаж нийт усанд автсан 36 айл өрхийн 19 гэр, 7 байшин, 2 орон сууцны 1 давхар, 7 албан байгууллагын В1 давхар, 1 гудамж талбай тус тус усанд автсан байсныг мотопомп ашиглан усыг соруулж аюулгүй байдлыг ханган ажиллав.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Нүдэн багийн "Данжуурын дэрс" гэдэг газар /аймгийн төвөөс баруун урд зүгт 143км-т, сумын төвөөс хойд зүгт 17 км-т/ нутагладаг малчин Л.Улаанхүү /68 настай, эрэгтэй/ 2024.09.25-ны өдрийн 15:00 цагийн орчимд гэрээсээ явган гараад сураггүй болсон тухай дуудлагыг 2024.09.28-ний өдрийн 10:17 цагт /10:17 цагт/ хүлээн авсан. Дуудлагын дагуу Онцгой байдлын газраас ЭХАС-ын бүлгийн дарга, ахлах дэслэгч Д.Төмөрбаатраар ахлуулсан бүлэг Онгон суманд 12:50 очиж, 2024.09.29-өдрийн

13:10 цагт эрлийн ажиллагааг эхлүүлж алга болсон иргэний гэрээс урд зүгт 10 км-н радиуст дотор эрэлч, аврагч нохойн хамтаар эрлийн ажиллагааг явуулсан үзэгдэх орчин хязгаарлагдмал зам явахад хүндрэлтэй байгаа тул эрлийн ажиллагааг 19:00 цагт зогсоож сумын төврүү буцсан. Нийт ОБГ-ын ЭХАС-ын 6 алба хаагч 1 автомашин 1 мотоциклтэй, ар гэрээс 6 хүн 1 автомашин нийт 12 хүн 3 тениктэйгээр ажиллаж байгаа.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 5-р баг “Зараа” гэдэг газар /аймгийн төвөөс зүүн зүгт 25 км-т сумын төвөөс баруун зүгт 30 км-т Сүхбаатар сумаас Баруун-Урт сумын чиглэлд зорчиж явсан иргэн Х.Ариунболдийн эзэмшлийн 5123УЕЗ улсын дугаартай Приус-41 загварын суудлын автомашин /2том хүн/ шаварт суусан тухай дуудлагыг 2024.09.29-ний өдрийн 07:51 цагт хүлээн авсан. Дуудлагын дагуу Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын 3 алба хаагч, Зил-131 автомашинтай 08:30 цагт гарч 11:40 цагт очсон. Шаварт суусан 5123 УЕЗ улсын дугаартай Prius 41 автомашин 2 зорчигч , 4446 СҮА улсын дугаартай Porter автомашин 5 зорчигчтой, 2931 УНР улсын дугаартай ЗИЛ-131 автомашин 2 зорчигчтой нийт 3 автомашин 9 зорчигч байсныг татан гаргаж ажилласан.

Баруун-Урт сумын 1,2,5,7,9 дүгээр багуудад 2024.09.28-ны өдрийн 10:17 цагаас 2024.09.29-ны өдрийн 13:20 цагийн хооронд үргэлжлэн орсон аадар бороо болон нойтон цас орсны улмаас 2024.09.29-ны 07:23 цагт үерт автсан нийт 6 дуудлагыг хүлээн авсан. Уг дуудлагын дагуу Онцгой байдлын газраас 3 алба хаагч 1 автомашинтай, ГТУА 15-р ангиас 10 алба хаагч 3 автомашинтай, Эрэн хайх аврах салбараас 4 алба хаагч 1 аютомашинтай, Улсын нөөцийн салбараас 2 алба хаагч нийт 19 алба хаагч, 5 автомашин, 5 бүлэг 2 мотопомптой, мэргэжлийн ангиас 14 албан хаагч, 4 автомашин 4 бүлэг 1 мотопомптой, Дөрвөлж ОНӨГ-аас 21 ажилтан 2 автомашин 1 мотопомптой 07:55 цагт гарч нийт усанд автсан 1 аж ахуйн нэгж 1 айл өрхийн 1 байшин, орон сууцны 1 давхарын 4 подвол, тус тус усанд автсан байсныг 9 цаг 05 минут мотопомп ашиглан усыг соруулж ажилласан.

10. Санхүү, ар талын чиглэлээр

Онцгой байдлын газрын 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг Сангийн яамны цахим хаягт байршуулсан. Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газарт 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлан, тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт, 144 дүгээр салбарын нөөцийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлан, тооллогын бүртгэл тооцоо бодсон акт зэрэг баримтыг нэгтгэж албан тоотоор хүргүүлж ажилласан байна. Аймгийн Татварын хэлтэст 2024 оны хагас жилийн хувь хүний орлогын албан татварын тайлан, төлбөрт хураамж, авто тээврийн хэрэгслийн тайланг цахимаар хүргүүлж баталгаажуулсан.

2024 оны 3-р улирлын байдлаар 2,773,419,800 төгрөгийн санхүүжилттэй. Үүнээс: 2,488,373,200 төгрөг нь цалин хөлс, 285,046,600 төгрөг нь урсгал үйл ажиллагааны зардал байна.

Алба хаагчдын 1-9 дугаар сарын цалинг бодон олгож, эрүүл мэндийн даатгалын тайланг аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст цаасаар баталгаажуулан цахимаар илгээсэн. 144 дүгээр салбарын бараа материалын хөдөлгөөний сарын мэдээг сар бүрийн 5 дотор Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газарт цаасаар хүргүүлсэн. Улсын нөөцийн салбарт хагас жилээр тэжээлийн борлуулалтын өр авлага үүсгэлгүй ажилласан. Онцгой байдлын газрын 1-9 дугаар сарын санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээр баталгаажуулан онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газарт хүргүүлэн, ажиллаж байна. Байгууллагын төсөв санхүү, гүйцэтгэл ил тод нээлттэй байх зорилгоор шилэн дансны мэдээллийг сар бүрийн 05-ний дотор дараах мэдээллийг байршуулж байна. Үүнд:

1. Байгууллагын батлагдсан орон тоо, түүнд орсон өөрчлөлтийн мэдээллийг 9 удаа байршуулсан бөгөөд батлагдсан орон тоо нууцын зэрэглэлд хамаардаг тул орон тооны мэдээллийг хасаж байршуулж байна.
2. Байгууллагын батлагдсан төсвийн мэдээллийг 9 удаа оруулсан.
3. Тухайн жилийн төсөвт орсон тодотгол, нэмэлт, өөрчлөлтийг 9 удаа байршуулж, төсөвт өөрчлөлт орсон үед тухай бүр тодотгож байна.
4. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар /сар, улирал, хагас, бүтэн жилээр/ мэдээллийг 9 удаа

5. Дараа жилийн төсвийн төслийг pdf файл болгон байршуулсан.
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг түлш халаалтын зардлаас “Дөрвөлж” ОНӨААТҮГ-т 22,7 сая төгрөг шилжүүлж, аймгийн Засаг даргын захирамжаар НИК ХХК-д тээвэр шатахууны 44,3 сая, МУЗГ-ын тогтоол, АЗД-ын захирамжийн дагуу хивэг, тэжээл, нүүрсний ачаа тээвэр болон автомашин худалдан авсны 278,5 сая төгрөгийг тус тус байршуулсан
7. Худалдан авах ажиллагааны мэдээллийг 9 удаа байршуулж ажилласан
8. Хандив, тусламжтай холбоотой мэдээллүүдийг үнэн зөв байршуулан ажиллаж байна.

Онцгой байдлын газрын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг мэргэжилтэн, анги, салбарын даргаас санал хүсэлтийн авч нэгтгэж, газрын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн албан тоотоор Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү,ар талын газарт хүргүүлсэн. Аймгийн Татварын хэлтэст 2024 оны 1,2 дугаар улирлын тайланг цахимаар илгээж баталгаажуулсан. 2024 оны 1,2 дугаар улирлын гамшиг ослын үед ажилласан авто тээврийн хэрэгслийн шатахууны зардал болох 79,212,276 төгрөгийн зардлын анхан шатны баримтыг нэгтгэж аймгийн Засаг даргын 7 удаагийн захирамж гаргуулан шийдвэрлүүлсэн.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим сайтад 2023 оны үндсэн хөрөнгийн хөдөлгөөний тайлан мэдээг нэгтгэж илгээн, анхан шатны баримтыг бүрдүүлж архивын баримт болгон үдсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас албан байгууллагад хийсэн шалгалтад 95А үнэлгээтэй дүгнэгдсэн.

2024 оны 1,2 дугаар улирлын гамшиг ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын 73 удаагийн дуудлагын 53,640,000 төгрөгийн томилолтын зардлыг нэгтгэж, Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газарт хүргүүлсэн.

11. Олон нийттэй харилцах хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч ажилласан талаар

Сүхбаатар аймгийн BBS телевизээр гамшиг, осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр, “Цаг агаарын сэрэмжлүүлэх мэдээ”, “Цахилгааны болон пийшин зуухны аюулгүй байдал”, “Бага насны хүүхдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлье”, “Үер, усны аюул”-аас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг шторкийг 7 хоногт 35 удаагийн давтамжтайгаар цаг үеийн мэдээ мэдээллийг шууд болон мэдээллийн цагаар иргэд олон нийтэд цаг алдалгүй нэвтрүүлэн сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулж байна.

Цаг үеийн нөхцөл байдлын мэдээ 7 удаа, шууд болон ярилцлага 8 удаа, бэлтгэн өгч хамтарч ажилласан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын, www.su.nema.gov.mn веб сайт болон Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын facebook, пэйж хуудсанд цаг үеийн мэдээ мэдээлэл болон урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмж, сэрэмжлүүлгийг 170 удаа байршуулсан. Орон нутгийн хамгийн их гишүүдтэй нэгдсэн сайтуудад шэйр хийж мэдээ мэдээллийг цаг алдалгүй шуурхай иргэдэд хүргэн ажиллаж байна.

Орон нутгийн сонинд 12 удаа мэдээлэл сэрэмжлүүлэг зөвлөмж бэлтгэн өгч урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

ХЯНАСАН:
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА Б.АНХБАЯР

ТАЙЛАН БИЧСЭН:
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН,
АХМАД Б.БАТЗОРИГ

5. Дараа жилийн төсвийн төслийг pdf файл болгон байршуулсан.
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг түлш халаалтын зардлаас "Дөрвөлж" ОНӨААТҮГ-т 22,7 сая төгрөг шилжүүлж, аймгийн Засаг даргын захирамжаар НИК ХХК-д тээвэр шатахууны 44,3 сая, МУЗГ-ын тогтоол, АЗД-ын захирамжийн дагуу хивэг, тэжээл, нүүрсний ачаа тээвэр болон автомашин худалдан авсны 278,5 сая төгрөгийг тус тус байршуулсан.
7. Худалдан авах ажиллагааны мэдээллийг 9 удаа байршуулж ажилласан.
8. Хандив, тусламжтай холбоотой мэдээллүүдийг үнэн зөв байршуулан ажиллаж байна.

Онцгой байдлын газрын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг мэргэжилтэн, анги, салбарын даргаас санал хүсэлтийн авч нэгтгэж, газрын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн албан тоотоор Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү,ар талын газарт хүргүүлсэн. Аймгийн Татварын хэлтэст 2024 оны 1,2 дугаар улирлын тайланг цахимаар илгээж баталгаажуулсан. 2024 оны 1,2 дугаар улирлын гамшиг ослын үед ажилласан авто тээврийн хэрэгслийн шатахууны зардал болох 79,212,276 төгрөгийн зардлын анхан шатны баримтыг нэгтгэж аймгийн Засаг даргын 7 удаагийн захирамж гаргуулан шийдвэрлүүлсэн.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим сайтад 2023 оны үндсэн хөрөнгийн хөдөлгөөний тайлан мэдээг нэгтгэж илгээн, анхан шатны баримтыг бүрдүүлж архивын баримт болгон үдсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас албан байгууллагад хийсэн шалгалтад 95А үнэлгээтэй дүгнэгдсэн.

2024 оны 1,2 дугаар улирлын гамшиг ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын 73 удаагийн дуудлагын 53,640,000 төгрөгийн томилолтын зардлыг нэгтгэж, Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газарт хүргүүлсэн.

11. Олон нийттэй харилцах хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч ажилласан талаар


Сүхбаатар аймгийн BBS телевизээр гамшиг, осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр, "Цаг агаарын сэрэмжлүүлэх мэдээ", "Цахилгааны болон лийшин зуухны аюулгүй байдал", "Бага насны хүүхдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлье", "Үер, усны аюул"-аас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг шторжийг 7 хоногт 35 удаагийн давтамжтайгаар цаг үеийн мэдээ мэдээллийг шууд болон мэдээллийн цагаар иргэд олон нийтэд цаг алдалгүй нэвтрүүлэн сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулж байна.

Цаг үеийн нөхцөл байдлын мэдээ 7 удаа, шууд болон ярилцлага 8 удаа, бэлтгэн өгч хамтарч ажилласан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын, www.su.nema.gov.mn веб сайт болон Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын facebook, пэйж хуудсанд цаг үеийн мэдээ мэдээлэл болон урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмж, сэрэмжлүүлгийг 170 удаа байршуулсан. Орон нутгийн хамгийн их гишүүдтэй нэгдсэн сайтуудад шэйр хийж мэдээ мэдээллийг цаг алдалгүй шуурхай иргэдэд хүргэн ажиллаж байна.

Орон нутгийн сонинд 12 удаа мэдээлэл сэрэмжлүүлэг зөвлөмж бэлтгэн өгч урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

ХЯНАСАН:
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА  Б.АНХБАЯР

ТАЙЛАН БИЧСЭН:
ГАМШИГЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН,
АХМАД  Б.БАТЗОРИГ

ЗУРГАН ТАЙЛАН







